

# КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2024 оны 3 сарын 15-ны өдөр

№24/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ийн өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам, ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн хурлын эчинээ санал хураалтыг тус тус үндэслэн “Крипто Үндэстэн” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

- “Крипто Үндэстэн” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхарт хуралдуулсугай.
- Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 5-ны өдрөөр тогтоосугай.
- Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
- Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
- Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
- Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
- Хурлын даргаар Ард Санхүүгийн Нэгдэлийн гүйцэтгэх захирал Ч.Ганхуягийг томилсугай.
- Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

# КРИПТО ҮНДЭСТЭН ХК

**Хурал зохион байгуулах комиссын дарга:**

“Крипто Үндэстэн” ХК, ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг

**Хурал зохион байгуулах комиссын гишүүд:**

“Крипто Үндэстэн” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Чадраабал

“Ард Бит” ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Тэлмүүн

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

**Тооллогын комиссын гишүүд:**

Т.Батбаяр (Ард Секюритиз YЦК ХХК)

Ө.Бямбагэрэл (Ард Секюритиз YЦК ХХК)

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Д.Чадраабал-д даалгасугай.

ДАРГА

Ч.ГАНХУЯГ

